



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өндөр хурдны интернэтийн үйлчилгээ /бүх алба, салбар/" үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Р.Амарбаясгалан
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хамтын
ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

Ц.Ган-Эрдэнэ
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Мэдээллийн
аюулгүй байдал, технологийн албаны Программ
хангамж хөгжүүлэлтийн хэсгийн дарга)

Т.Дамдинсүрэн
(“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл” Төрийн бус
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Т.Ундрах
(“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн
(тохиролцсоноор))

Нарийн бичгийн
дарга:

О.Тэмүгэ
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах
ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Р.Амарбаясгалан)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (О.Тэмүгэ)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА